



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 22 өдөр

Дугаар А/186

Мөрөн сум

Гадаад албан томилолтоор  
ажиллуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Засгийн газрын 2013 оны 169 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн гадаад бодлого, үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангах журам"-ын 4 дүгээр бүлгийн 4.6 дугаар заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Бүгд Найрамдах Солонгос Улсын Нутгийн удирдлагын хөгжлийн институт (LOGODI)-тэй хамтран хэрэгжүүлж байгаа Монгол Улсын нутгийн захиргааны байгууллагын удирдах албан тушаалтныг чадавхжуулах сургалтад аймгийн Засаг даргын Тамгын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Р.Машбатыг оролцуулж, 2024 оны 05 дугаар сарын 19-26-ны өдрүүдэд Бүгд Найрамдах Солонгос Улсад гадаад албан томилолтоор ажиллуулсугай.

2.Гадаад албан томилолтоор ажиллаж, сургалтад хамрагдсан тухай илтгэх хуудсыг ажлын 5 хоногийн дотор удирдлагуудад танилцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (Р.Машбат)-д даалгасугай.

3.Энэхүү захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Батбилгүүн)-д үүрэг болгосугай.

ДАРГА  П.ЛХАГВАЖАВ

